



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

“Ардкредит ББСБ” ХХК-ийн
хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ардкредит ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай, нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,500 ширхэг, нийт 550,000,000 /таван зуун тавин сая/ төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Ардкредит ББСБ” ХХК /Ч.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000020